

Ard

Нэгж эрх эзэмшигчдийн хурал
MSE:XOC

Хурлын дэг

14:50-15:15	Хурлын ирц бүртгэх
15:15-15:20	Хурлын ирцийг мэдээлэх
15:20-15:30	Хурлын дарга хурлыг нээж, хурлын дэг танилцуулах
15:30-16:20	Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах, санал хураалт явуулах
16:20-16:30	Хэлэлцэх асуудал тус бүрээр санал хураалт
16:30-16:45	Тооллогын комиссын тогтоол танилцуулах
16:45-16:55	Хурлаас гарах тогтоолыг танилцуулах
17:00	Хурлыг хаах

**ХУРЛЫН ИРЦ,
ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ №1



ҮНДЭСНИЙ
ХУВЬЧЛАЛЫН
САН

“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХАМТЫН ХОС-ИЙН НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ №1

2026 оны 4 сарын 28-ны өдөр

Нэгж эрх эзэмшигчдийн хурлын ирцийн тухай болон
Хурлын хүчин төгөлдөр тооцох тухай

Компанийн нэр: “ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХАМТЫН ХОС

Хурлын төрөл: Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурал

Нэгж эрх эзэмшигчдийн хурал хуралдсан огноо, газар: 2026 оны 04 сарын 28-ны 15:00 цагт, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Сүхбаатарын талбай-2, Сентрал Тауэр, 17 давхар, Криптос ресторан

Бүртгэлийн өдөр: 2026 оны 04 сарын 08-ны өдөр

Нэгж эрх эзэмшигчдийн хурлын урьдчилсан саналын хуудас ирүүлсэн сүүлийн хугацаа: 2026 оны 04 сарын 24-ны өдрийн 16:00 цаг хүртэл

Тооллогын комисс: Ө.Бямбагэрэл

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10 болон 9 дүгээр зүйлийн 9.1 дүгээр зүйлд зааснаар мөн Санхүүгийн зохицуулах хорооны “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.1 болон 9.7 дугаар хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ :**

1. Үндэсний Хувьчлалын сан ХОС-ийн нийт гаргасан ширхэг нэгж эрх байна. Үүнээс саналын эрхтэй ... ширхэг нэгж эрхбуюухувийг эзэмшиж байгаа нэгж эрх эзэмшигчид хуралд оролцож байна.
2. Санхүүгийн зохицуулах хорооны “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.1 болон 9.7 дугаар хэсгийг тус тус үндэслэн тус хурал хүчин төгөлдөр болно.

Хэлэлцэх асуудлууд

1. Ард Менежмент компанийн итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайлан
2. Үндэсний Хувьчлалын хамтын Сан хамтын ХОС-ийн 2025 оны үйл ажиллагааны тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах
3. Кастодиан банкны хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайлан
4. Үндэсний Хувьчлалын Сан ХОС-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлт
5. Үндэсний Хувьчлалын Сан Хамтын ХОС-ийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах
6. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах
7. ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийг батлах тухай
8. Кастодиан банк өөрчлөх шийдвэрийг батлах
9. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
10. “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн хөрөнгө оруулалтын бодлогод өөрчлөлт оруулах
11. “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн нэгж эрхийн танилцуулгад өөрчлөлт оруулах.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 1

Ард Менежмент компанийн итгэмжлэн
удирдах үйлчилгээний жилийн тайлан

КОМПАНИЙН ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Хөрөнгө итгэмжлэн удирдах

Цэвэр хөрөнгийн
үнэлгээ
7.58 тэрбум төгрөг

Сангийн өдөр тутмын үйл ажиллагаа

- Сангийн хөрөнгийн бүртгэлийг хөтлөх, хадгалах, тайлан мэдээ бэлтгэх
- СЗХ, МХБ-тэй хамтран ажиллав.
- Сангийн үйл ажиллагааг зохицуулах журам, зааварчилгаа, хэрэгжилтийг хангаж ажиллав.

ТУЗ-ийн хурлыг зарлан хуралдуулах

Сангийн ТУЗ-ийн
3 хурал, 4 эчнээ
санал хураалтыг
зохион байгуулав.

НЭЭХ-ыг зохион байгуулах, тайлан мэдээ бэлтгэх

2026/04/28-ны
өдөр НЭЭХ-г
зохион байгууллан
ажиллаж байна



МЕНЕЖМЕНТ
КОМПАНИ



Ард Менежмент нь
санг үүсгэн
байгуулах, удирдах
чиглэлээр ажиллаж
эхэлсэн



“Үндэсний
Хувьчлалын Сан”
₮4.75 тэрбум татан
төвлөрүүлсэн



“Үндэсний
Хувьчлалын Сан”
цэвэр хөрөнгийн
үнэлгээ ₮9.3 тэрбум
төгрөг хүрсэн



Монголын
хамгийн анхны
хамтын нээлттэй
санг үүсгэн
байгуулсан



Хөрөнгө оруулалтын
сан байгуулах



Сан болон хувь хүний
хөрөнгийн удирдлага



Судалгаа, шинжилгээ



ХУВЬЧЛАЛ



Хөрөнгө
оруулалтын
бодлого



Мэргэжлийн
туршлагатай баг




Дотоод болон гадаад
хөрөнгө оруулалт хийх
боломжтой дэд бүтэц

ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН


“Үндэсний Хувьчлалын Сан”
хамтын ХОС

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН



2025 онд эдийн засаг хүлээлтээс өндөр гүйцэтгэлтэй гарлаа:

- Цаг агаарын нөхцөл байдал таатай байж, малын зүй бус хорогдол бага, мал төллөлт сайн байснаар хөдөө аж ахуйн салбар сэргэлттэй байсан
- 2025 оны эхэн үед гадаад тогтворгүй байдлаас шалтгаалан нүүрсний экспорт огцом буурч байсан бол II хагаст биет экспортын хэмжээ нэмэгдсэнээр уул уурхай, түүнийг дагасан тээврийн салбарын өсөлт нэмэгдэв.




Инфляцад голчлон нөлөөлж буй зүйлс:

- Тариалангийн бүс нутгуудаар гантай байсан нь хүнсний бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлсэн
- Мах, махан бүтээгдэхүүний үнэ улирлын тогтсон онцлогийн эсрэг чиглэлд өсөв
- Өрхийн цахилгааны суурь үнийн нөлөө арилснаар төрийн зохицуулалттай үйлчилгээний инфляц буурсан
- Хатуу түлш ба гэр ахуйн барааны үнэ өсөв

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ОРЧИН


тэрбум төгрөг



МХБ-ийн зах зээлийн үнэлгээний өсөлт 2025 онд саарлаа

- Хоёр жил дараалан хурдацтай тэлж байсан хөрөнгийн зах зээлийн өсөлт 2025 онд саарлаа
- МХБ-ийн I ба II ангиллын компаниудын индексийн өсөлт 2025 онд саарсан бол III ангиллын компаниудын индекс агшилттай байлаа

тэрбум төгрөг



МХБ-ийн нийт арилжаа 574 тэрбум төгрөгөөр буурлаа

- Компаниуд дотоодын зах зээл дээр IPO хийгээгүйн зэрэгцээ хоёрдогч арилжааны идэвх буурав
- Дотоодын томоохон компаниуд олон улсын зах зээл дээрээс санхүүжилт татсанаас гадна ЗГҮЦ-ны хэмжээ буурсан нь арилжааны идэвхийг сулрууллаа

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ

ЗАХ ЗЭЭЛИЙН ХАНШ

97.92

MoM

+3.6%

YTD

-14.8%

Анхны үнээс

-2.8%

Жилийн дээд доод

113.48-80.10

ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ҮНЭ(NAV)

151.16

MoM

+7.1%

YTD

+12.3%

Анхны үнээс


+51.2%

Жилийн дээд доод

151.16-120.86




ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



*"Үндэсний Хувьчлалын Сан" хамтын ХОС-ийн үнэт цаасны танилцуулга

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БҮТЭЦ



Дотоод хувьцаа
Гадаад хувьцаа
Үнэт цаас

24 ХУВЬЦАА

6 ХУВЬЦАА

1 ҮНЭТ ЦААС

Багцад эзлэх хувь

	Дундаж	Өндөр
Дотоод хувьцаа	3.2%	8.6%
Гадаад хувьцаа	1.6%	3.8%
Үнэт цаас	6.9%	6.9%

ХУВЬЦААНЫ БАГЦ

Технологи



Уул уурхай



Тогтмол хэрэглээ



Санхүү



Тогтмол бус хэрэглээ




ОНЦЛОХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ




2025 II улирал Одоо
1.70% → 0.00%
Багцад эзлэх хувь




2025 II улирал Одоо
1.60% → 0.00%
Багцад эзлэх хувь



ЯМАР САЛБАРТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙСЭН БЭ?



НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧИД



	12/31/2024		Өөрчлөлт	12/31/2025	
АРД ДААТГАЛ ХК	5,658,294	11.3%	(428,508)	5,229,786	10.5%
АРДЫН ТЭТГЭВРИЙН ДАНС	2,847,851	5.7%	779,452	3,627,303	7.3%
ТУЛГА	2,999,610	6.00%	-	2,999,610	6.0%
АРД МЕНЕЖМЕНТ	2,500,000	5.0%	7,445	2,507,455	5.1%
М СИ ЭС ИНВЕСТМЕНТ	2,500,000	5.0%	-	2,500,000	5.0%
АРД КРЕДИТ ББСБ	1,558,998	3.1%	-	1,558,998	3.1%
БОГД БАНК	1,371,500	2.7%	-	1,371,500	2.7%
МАНДАХБАЯР	1,000,000	2.0%	-	1,000,000	2.0%
НАРАНБАТ	1,000,000	2.0%	-	1,000,000	2.0%
ЦЭРЭНДОЛГОР	807,141	1.6%		807,141	1.6%
ТОП-10	22,243,394	44.5%		22,601,783	45.2%
Нийт дүн	50,000,000	100.00%		50,000,000	100.00%


Нийт нэгж эрх эзэмшигчдийн тоо-7,100

САНХҮҮГИЙН ТАЙЛАН (АУДИТЛАГДСАН)

Орлого үр дүнгийн тайлан (сая төгрөг)

Үзүүлэлт	2024	2025
Хүүгийн орлого	41	38
Ногдол ашгийн орлого	167	235
Бодит үнэ цэнийн өсөлтийн олз	428	818
Нийт ашиг (алдагдал)	636	1,091
ХОМК-ийн үйлчилгээний зардал	(153)	(148)
Кастодианы үйлчилгээний зардал	(23)	(19)
Бусад зардал	(77)	(129)
Нийт үйл ажиллагааны зардал	(253)	(296)
Татварын өмнөх ашиг	383	795
Хойшлогдсон татварын зардал	(3)	(4)
Тайлант үеийн цэвэр ашиг	380	791

САНГИЙН ЗАРДАЛ



ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 2

Үндэсний Хувьчлалын Сан ХОС-ийн
2025 оны тайланд ТУЗ-өөс гаргасан
дүгнэлт

САНГИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



Б.Золбоо

ТУЗ-ийн дарга



Г.Цогбадрах

ТУЗ-ийн гишүүн



Ч.Хандаа

ТУЗ-ийн гишүүн



П.Баянсан

ТУЗ-ийн хараат бус
гишүүн



Б.Ариунболд

ТУЗ-ийн хараат
бус гишүүн

ТУЗ-ИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТЭЭС



ТУЗ-ийн хурал

3 удаа



2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан цаг тухай бүрт бэлтгэн хүргүүлсэн.



Эчнээ санал хураалт

4 удаа



Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, компанийн тухай хууль, ХОС-ийн дүрэм журмын хүрээнд ажилласан.

Гүйцэтгэх удирдлага нь дор дурдсан мэдээллүүд, тайлангуудыг хүргэж ажилласан байна.

- ✓ Улирал бүр ТУЗ-ийн хурлыг хуралдуулж сангийн үйл ажиллагаа, үр дүнг танилцуулах, шаардлагатай шийдвэрүүдийг гаргуулах
- ✓ Улирал бүр Earnings Call хийж сангийн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг олон нийтэд хүргэх
- ✓ Сангийн хагас болон бүтэн жилийн тайланг бэлтгэж олон нийт болон зохицуулах байгууллагад хүргүүлэх
- ✓ Зохицуулагч байгууллагуудтай харилцах, хяналт шалгалт, хөндлөнгийн аудит хийлгэх
- ✓ Кастодиан банканд сангийн хөрөнгийг хадгалуулах, тайлан мэдээний үнэн зөв байдалд хяналт тавих

Иймд гүйцэтгэх удирдлагын багийг Монгол улсын хамгийн анхны ХОС-ийн үйл ажиллагааг хууль журмын дагуу удирдаж ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна. Мөн цаашид хөрөнгө оруулалтын бодлогод тусгасан төлөвлөсөн өгөөждөө хүрч ажиллахыг Сангийн менежер болон гүйцэтгэх удирдлагад үүрэг болгож байна.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 3

Кастодиан банкны хөрөнгө хадгалах
үйлчилгээний жилийн тайлан

VISION

Mongolia's Global
Benchmark Bank

MISSION

The genesis of
Prosperity

КАСТОДИАН БАНК

“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛ ХААЛТТАЙ
ХАМТЫН ХОС”-д

2025 онд үзүүлсэн кастодиан банкны
үйлчилгээний тайлан

АГУУЛГА

01

КАСТОДИАН БАНК


02

ГОЛОМТ КАСТОДИАН

03

ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН

ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУД



- Хөрөнгө хадгалах
- Тухайлсан бүртгэл хөтлөх
- Эцсийн өмчлөгчийн тодорхойлох

КАСТОДИАН БАНК



- Хууль, дүрэм журам

- Зохицуулагч байгууллагууд

- Хөрөнгө оруулагчийн эрх ашиг

- ХОС-ийн хөрөнгийг хадгалах **нэгж эрхийн тухайлсан бүртгэл хөтлөх, ХОС-ийн цэвэр активын өртөгийг тооцох, зах зээлд эргэлтэнд байгаа нийт нэгж эрхийн тоог зөв тодорхойлсон эсэхэд хяналт тавих**
- Үнэт цаас **өмчлөгчийн өмчлөл** дэх үнэт цаасыг **найдвартай хадгалах** болон үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх болон бусад эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйлчилгээг үзүүлэх



КАСТОДИАН БАНКНЫ ТҮҮХЭН ТОВЧООН



ҮНДЭСНИЙ
ХУВЬЧЛАЛЫН
САН

2015

Notura систем
Анхны харилцагч



2017

JP Morgan
саб-кастодиан



2020

Клирингийн Ерөнхий Гишүүн
Анхны хаалттай хамтын ХОС



2023

Хамтын Биржээр
Арилжаалагддаг ХОС

ИНВЕСКОР ГЛОБАЛ КЬЮ

ХАМТЫН БИРЖЭЭР АРИЛЖААЛАГДДАГ САН

2025

Биржийн бус
зах зээлийн холболт

OTC Platform



Кастодианы тусгай
зөвшөөрөл

Төвлөрсөн
хадгаламжийн
гишүүнчлэл

Олон улсын
ISAE 3402 стандарт

Хамгийн том
Хамтын ХОС

Зах зээлийн 50-иас
дээш хувь

2014

2016

2018

2021

2024

Яагаад Голомт кастодиан бэ?

БҮРТГЭЛИЙН СИСТЕМ



ICS СИСТЕМ

- Хөгжүүлэгч компани – NOMURA RESEARCH INSTITUTE /Tokyo, Japan/
- 2015 оноос 10 жилийн турш шаардлагатай хөгжүүлэлтийг хийлгэв.
- МХБ, ҮЦТХТ, МҮЦКТ-ийн систем холболт хийгдсэн.
- 24/7 системийн тасралтгүй ажиллагааг хангах SUPPORT SERVICE вендор компаниас авдаг.
- Автомат тайлагналын систем.

SUB-CUSTODIAN BANK



J.P. MORGAN BANK

- 2018 оноос тус банкны Дэд Кастодиан Банкаар хамтран ажиллаж байна.
- 7 дах жилдээ тус банкны жил бүрийн магадлан шинжилгээ буюу DUE DILIGENCE-г амжилттай хамгаалан хамтын ажиллагаагаа хадгалав.
- Сар бүрийн тайлан мэдээг хүргүүлэн, зах зээлийн талаарх мэдээллийг тухай бүр хүргүүлж ажиллаж байна.

ТАСРАЛТГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА



- Системийн **ГАМШИГИЙН ҮЕД АЖИЛЛАХ ГОРИМ**-ийн туршилтыг хагас жил тутамд зохион байгуулдаг.
- **БИЗНЕСИЙН ТАСРАЛТГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**-г хангаж ажилладаг
- Системийн хянал, эрхийн тохиргоог хагас жил тутам хянан баталгаажуулдаг.
- **ISO 20022** нэвтэрсэн.
- **ISAE 3402**

НАЙДВАРТАЙ БАЙДАЛ



МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ


- Мэдээллийн аюулгүй байдлын стандартуудыг хангаж ажилдаг.
- Харилцагчдын хөрөнгө банкны хөрөнгөөс тусгаарлагдаж хадгалагддаг.
- Банкны **ДОТООД АУДИТ**-с тогтмол үйл ажиллагааны зайны аудит хийгддэг.
- Эрсдлийн удирдлагын **RCSA** тогтолцоог хэрэгжүүлж сар бүр тайлагнадаг.

КАТОДИАН БАНКНЫ ТОЙМ




ҮНДЭСНИЙ
ХУВЬЧЛАЛЫН
САН


ЗАХ ЗЭЭЛИЙН ХУВЬ
(ХОС-н тоогоор)



ЗАХ ЗЭЭЛИЙН ХУВЬ
AUC %



Хамтын сангийн ЗАХ
ЗЭЭЛИЙН % (ХОС-н тоогоор)



ТООН
ҮЗҮҮЛЭЛТ
2025



ҮЦК 24
Клиринг 8

Иргэн / байгууллага



1800+



Хөрөнгө оруулалтын сан

25+

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ, НӨХЦӨЛ



НЭГЖ ЭРХИЙН ЦЭВЭР ҮНЭЛГЭЭ

ХӨРӨНГӨ /сая.төг/

Хувьцаа
5,976.2

Хадгаламж
184.7



Бэлэн мөнгө
581.1

Сангийн нийт
хөрөнгө: **₮ 7.58**
тэрбум төгрөг


Нийт гаргасан нэгж
эрх: **50,000,000.00**

Хасагдах зардал

Нэгж эрхийн цэвэр
үнэлгээ: **₮ 151.16**



ХӨРӨНГӨ ХАДГАЛАЛТ




БҮРТГЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА




ҮНДЭСНИЙ
ХУВЬЧЛАЛЫН
САН


Иргэн харилцагчийн тоо



Байгууллагын харилцагчийн тоо



Нэгж эрхийн цэвэр үнэлгээ / NAV /



Өдөр бүр, нийт 365 удаагийн тооцоолол хийж тулган баталгаажуулсан



Гадаад хувьцааны 1 удаагын, дотоодын компаний хувьцааны 24 удаагын 247.8 сая төгрөгийн ногдол ашгийн төлөлтийг харилцагчийн дансанд байршуулсан.



Хөрөнгийн үлдэгдлийн тайлан, NAV тайлан, дансны гүйлгээний дэлгэрэнгүй тайлан, шитмгэлийн тайлан г.м



Мөнгөн хөрөнгийн 794 сая.төгрөг бүхий гүйлгээ болон 2,168,118 ширхэг 1.78 тб.төгрөгийн үнэлгээ бүхий хувьцаа худалдан авах, худалдан борлуулах арилжааг зохион байгуулсан байна.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 4

**2025 оны санхүүгийн
тайлан, түүнд хийсэн хараат бус
аудитын дүгнэлт**

Удирдлагын Захидал

“Үндэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС

**2025 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар
болгосон жилийн эцсийн санхүүгийн тайлан**

 **Нексия Глобал Монголиа Аудит ХХК**

Эмбасси Уан Бюлдинг, 606 тоот, 6-р
давхар, Элчингийн гудамж 15А, 1-р
хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар
14220, Монгол Улс

2026 оны 4 дугаар сарын 28

Нексия Глобал Монголиа Аудит ХХК – н тухай

Нексия Глобал Монголиа Аудит ХХК нь үйл ажиллагаагаа 2021 оноос явуулж эхэлсэн бөгөөд 2022 оноос эхлэн Нексия Интернэшнлийн Монгол Улс дах албан ёсны хараат бус гишүүн байгууллагаар ажиллаж эхэлсэн билээ.

Нексия Интернэшнл нь дэлхийн 125 улсад үйл ажиллагаа явуулдаг 270 гаран гишүүн компаниудын 790 гаран оффисуудыг эгнээндээ нэгтгэсэн дэлхийд **ТОП-8** ордог аудит, нягтлан бодох бүртгэл, татвар болон бизнесийн зөвлөх үйлчилгээний тэргүүлэгч компани юм.

Бид 45-аас дээш ажилтан, 8-аас дээш түншүүдтэйгээр танай зорилгод хүрэх, ирээдүйн амжилтыг төлөвлөхөд зориулсан тусгайлсан шийдэл, бодитой зөвлөмжийг хүргэж байна. Манай аудитын багийн 50 гаруй хувь нь АССА болон АССА-ийн гишүүдээс бүрддэг.

Nexia International


Nexia International is a leading, global network of independent accounting and consulting firms. When you choose a Nexia firm, you get a more responsive, more personal partner-led service, across the world.

Awards and credentials



Service lines

Advisory Audit Tax



Гэрээт ажлын зорилго


2025 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн тайлангууд нь материаллаг зүйлсийнхээ хувьд Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, холбогдох бусад журам, заавар, аргачлал болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу илэрхийлэгдсэн гэдэгт аудиторын дүгнэлт гаргаж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мэргэжлийн туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх.

Аудитын үйл явц

- ✓ Үйлчлүүлэгчийн онцлог нөхцөл байдлыг судлах, танилцах ажлын талаар танилцах
 - Санхүүгийн хэлтэс болон бүртгэлийн үйл ажиллагааны зохион байгуулалт
 - Удирдлагын бүтэц зохион байгуулалт, тэдгээрт гарсан өөрчлөлтүүд, ажлын ур чадварын ерөнхий төвшин
 - Дотоод хяналтын үйл ажиллагаа, энэ нь хэрхэн үр дүнтэй зохион байгуулагдсан байдал
 - Гадаад, дотоодын томоохон харилцагчид, бэлтгэн нийлүүлэгчдийн талаархи мэдээлэл, тэдгээртэй байгуулсан гэрээ хэлцлүүд, гэрээний биелэлтүүд гэх мэт
- ✓ Аудитын чухал асуудлууд ба хэрэглэх аргуудыг боловсруулах
 - Компанийн санхүүгийн тайлангаархи хөрөнгийн үлдэгдлийг биет шалгалтаар (хэсэгчлэн); орлого, зарлага, эх үүсвэрийн дансдын үлдэгдэл, тайлант хугацааны ажил гүйлгээг сонгох, түүвэрлэх, тестлэх, асууж ярилцах, тулган шалгах, давтан гүйцэтгэх зэрэг аудитын горимуудаар шалгаж баталгаажуулах гэх мэт
- ✓ Эрсдлийн хүчин зүйлүүд ба материаллаг чанарыг үнэлэх

Аудитын үйл явц

Бид аудитын ажлын ерөнхий төлөвлөгөөг доор харуулсан ба удирдлагын шаардлага, компанийн үйл ажиллагаануудаас хамааран өөрчлөгдөх боломжтой.



Аудитын баг

Гүйцэтгэх захирал:

Э.Булган
ACCA, МНБ, MSc

Аудит партнер:

У.Нарандэлгэр
Аудитор, МНБ

Аудитын татварын партнер:

М.Энхмэнд
МНБ, ТМЗ, MSc

Аудит менежер:

Д.Баярсайхан
МНБ, ТМЗ

Аудитын туслах:

Б.Ундармаа
Нягтлан бодогч, GAPE Academy

Санамж

Энэхүү тайланг зөвхөн Хөрөнгө Оруулагч Үндэстэн Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан ХХК – д зориулан бэлтгэсэн бөгөөд өөр зорилгоор ашиглах ёсгүй. Мөн бид энэхүү тайлангийн үндсэн дээр гаргасан аливаа үйлдэл, шийдвэр, хуулийн байгууллагад хандсанаас үүдэн гарсан аливаа хохирол, хохирлыг хариуцахгүй. Нексия Глобал Монголиа Аудит ХХК-аас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр энэхүү тайланг бусад тал ашиглах ёсгүй. Энэ хэсгийн заалттай харшлах манай тайлан, эсхүл тэндээс авсан аливаа хуулбарыг тараасан, нийтэлсэн, олируулсан, ашигласны улмаас Компани болон гуравдагч этгээдэд учирсан хохирлын төлөө бид хариуцлага хүлээхгүй.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 5

**“Үндэсний Хувьчлалын Сан”
Хамтын ХОС-ийн дүрмийн
нэмэлт, өөрчлөлтийг батлах**

“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ДҮРЭМД ОРОХ **НЭМЭЛТ ЗААЛТ**



№	Зүйл, Бүлэг заалт	Нэмэлтээр орсон заалтын агуулга
1	4.8, 4.9, 4.10. Сангийн хөрөнгө, санд хөрөнгө оруулах хэрэгсэл, активыг байршуулахад тавигдах шаардлага, хөрөнгө оруулалтын хэрэгсэл тус бүрийн эрсдэлийн удирдлага	<p>Сан нь энэхүү Дүрмийн 4.1-д заасан зарласан нэгж эрхийн 5 хүртэлх хувь буюу 2,500,000 ширхэг хүртэлх нэгж эрхийг нэгж эрхийн зах зээлийн ханш тухайн үеийн цэвэр хөрөнгийн үнэлгээ (NAV)-ээс 15 ба түүнээс дээш хувиар бага үнэлэгдэж байгаа тохиолдолд зах зээлээс эргүүлэн авах ажиллагааг хэрэгжүүлж болно.</p> <p>Энэхүү Дүрмийн 4.8 дахь хэсэгт заасан Сангийн нэгж эрхийг буцаан худалдан авах ажиллагаа нь Сангийн нэгж эрхийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, нэгж эрх эзэмшигчдийн эрх, ашгийг хамгаалах зорилготой байх бөгөөд Сангийн ТУЗ-өөс баталсан журам болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжинэ.</p> <p>Сан нь буцаан худалдан авсан нэгж эрхээ Сангийн үйл ажиллагааны хугацаа дуусахаас өмнө нэгж эрхийн цэвэр хөрөнгийн үнэлгээ (NAV), Сангийн ТУЗ-өөс баталсан журам, холбогдох шийдвэрийн дагуу зах зээлд буцаан арилжиж болно.</p>
2	5.6. Сангийн нэгж эрх эзэмшигч	Сангийн гишүүний бүртгэлийг Санд үйлчилгээ үзүүлж байгаа менежментийн компани 5.5-д заасан нэгж эрхийн тухайлсан бүртгэлд үндэслэн, сангийн холбогдох дотоод журамд заасны дагуу хөтөлнө.
3	11.1, 11.2, 11.3. Нэгж эрх эзэмшигчдийн хурал	<p>Сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг Компанийн тухай тухай хууль, эрх бүхий байгууллагаас баталсан холбогдох дүрэм, журамд заасны дагуу зохион байгуулна.</p> <p>Сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулаагүй тохиолдолд хурлыг хуралдуулбал зохих хугацаа өнгөрсөн өдрөөс эхлэн сангийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх дуусгавар болсонд тооцох ба мөн хугацаанаас хойш байгуулсан аливаа гэрээ хэлцэл, гаргасан шийдвэр хүчин төгөлдөр бус байна.</p> <p>Сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлаар Сангийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ болон Менежментийн компанийн дүгнэлтийг заавал хэлэлцэнэ.</p>
4	11.4.1, 11.4.2, 11.4.3. Дараах асуудлыг Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ. Үүнд:	<p>Менежментийн компанийг сонгох, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулах шийдвэр гаргах;</p> <p>Кастодианыг сонгох, хөрөнгө хадгалах гэрээ байгуулах шийдвэр гаргах;</p> <p>Менежментийн компани болон кастодианы төлбөр, урамшууллын дээд хязгаарыг тогтоох;</p>

“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ДҮРЭМД ОРОХ **НЭМЭЛТ ЗААЛТ**



№	Зүйл, заалт	Бүлэг	Нэмэлтээр орсон заалтын агуулга
5	11.6.	Нэгж эрх эзэмшигчдийн хурал	Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурал хуралдуулахтай холбогдон гарах зардлыг Сан хариуцна.
6	13.7.8.	Сангийн менежер нь дараах эрх, үүрэгтэй	Холбогдох хууль тогтоомж, хэм хэмжээний актад заасны дагуу эрх бүхий байгууллага, нэгж эрх эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийг мэдээллээр хангах,
7	18.3.	Хөрөнгө оруулалтын нягтлан бодох бүртгэл	Сангийн нягтлан бодох бүртгэлийг хөтөлж байгаа этгээд нь эрх бүхий мэргэшсэн нягтлан бодогч байна.

“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ДҮРЭМД ОРОХ **ӨӨРЧЛӨЛТ**

№	Зүйл, заалт	Бүлэг	Хуучин заалт	Өөрчлөн найруулсан заалт
1	6.1.	Хөрөнгө оруулалтын менежментийн компани	“Ард Менежмент” ҮЦК ХХК	“Ард Менежмент” ХХК
2	7.1.	Кастодианы үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд	Кастодиан банк: Голомт банк ХК Регистрийн дугаар, тусгай зөвшөөрлийн дугаар: 2075377 Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж, Очир Төв, Голомт Кастодиан, 503 тоот Утас, цахим хуудас: custody@golomtbank.com	Кастодиан банк: “Хаан Банк” ХХК Регистрийн дугаар, тусгай зөвшөөрлийн дугаар: 2693321 Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15 хороо, Чингэлтэйн өргөн чөлөө – 6, стадион оргил-1 Утас, цахим хуудас: custodian@khanbank.com

“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ДҮРЭМ **ХАСАХ ЗААЛТ**



№	Зүйл, заалт	Бүлэг	Хасах заалт
1	11.4	Нэгж эрх эзэмшигчдийн хурал	Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл нэгэн адил хамаарна.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 6

**Ногдол ашиг хуваарилах эсэх
тухай ТУЗ-ийн шийдвэрийг
танилцуулах**

2026 он 02 сар 12 өдөр

Дугаар 26/01

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Ногдол ашиг хуваарилахгүй байх тухай

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, "Үндэсний Хувьчлалын Сан" Хамтын ХОС (цаашид "ХОС" гэх)-ийн дүрмийн 12 дугаар зүйл, 16 дугаар зүйлийн 16.3 дах хэсгийг тус тус удирдлага болгон ХОС-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. ХОС-ийн Нэгж эрхийн танилцуулгад тусгасан зорилтот өгөөжийн хувь хэмжээний шаардлага хангагдаагүй тул 2025 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Ногдол ашиг хуваарилахгүй тухай тогтоол, мэдэгдлийг ХОС-ийн нэгж эрх эзэмшигчид, эрх бүхий байгууллагад мэдэгдэх ажлыг зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн энэхүү тогтоолын талаар ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн ээлжит хуралд танилцуулахыг Сангийн менежер У.Сүхдарьд даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Б.ЗОЛБОО

2025 оны санхүүгийн жилийн гүйцэтгэлийн дүнгээс үзэхэд сан нь эерэг цэвэр ашигтай ажилласан хэдий ч Нэгж эрхийн танилцуулгад тусгасан зорилтот өгөөжийн хувь хэмжээний шаардлагыг бүрэн хангаж чадаагүй үзүүлэлттэй байна. Иймд сангийн хөрөнгийн өсөлтийг дэмжих, багцын өгөөжийг нэмэгдүүлэх, цаашдын хөрөнгө оруулалтын боломжийг алдагдуулахгүй байх бодлогын үүднээс тухайн тайлант жилийн цэвэр ашгийг ногдол ашиг хэлбэрээр хуваарилах нь оновчгүй гэж үзэж байна.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 7

**ТУЗ-ийн 2026 оны үйл
ажиллагааны зардлын төсөв
батлах**

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны 2025 оны зардлын төсвийг доорх бүтэцтэйгээр санал оруулав.

Төсөв	Тоо ширхэг	Давтамж	Нэгж(төгрөг)
ТУЗ-ийн дарга	1	4	2,000,000
ТУЗ-ийн гишүүн	4	4	1,000,000
ТУЗ-ийн нарийн бичиг	1	4	400,000
ТУЗ-ийн хурал зохион байгуулах	1	4	250,000

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 8

**Кастодиан банк өөрчлөх
шийвэрийг батлах**

Кастодиан банк өөрчлөх шийвэрийг батлах

Бүлэг	Хуучин заалт	Өөрчлөн найруулсан заалт
Кастодианы үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд	<p>Кастодиан банк: Голомт банк ХК Регистрийн дугаар, тусгай зөвшөөрлийн дугаар: 2075377</p> <p>Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж, Очир Төв, Голомт Кастодиан, 503 тоот</p> <p>Утас, цахим хуудас: custody@golomtbank.com</p>	<p>Кастодиан банк: “Хаан Банк” ХХК</p> <p>Регистрийн дугаар, тусгай зөвшөөрлийн дугаар: 2693321</p> <p>Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15 хороо, Чингэлтэйн өргөн чөлөө – 6, стадион оргил-1</p> <p>Утас, цахим хуудас: custodian@khanbank.com</p>

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 9

**Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг сонгох**

САНГИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



Х.Билгүүн

ТУЗ-ийн дарга

Мэргэжил: Олон улсын эдийн засгийн онол

Албан тушаал: “Ард Секюритиз ҮЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал, АСН ХК-ийн Хөрөнгө оруулалт эрхэлсэн захирал



Г.Цогбадрах

ТУЗ-ийн гишүүн

Мэргэжил: Эдийн засагч, санхүүч

Албан тушаал: “Ард Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, “Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн



Ч.Даваасамбуу

ТУЗ-ийн гишүүн

Мэргэжил: Санхүү менежмент

Албан тушаал: “Ард Менежмент ХХК”-ийн Гүйцэтгэх захирал



П.Баянсан

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Мэргэжил: Бизнесийн удирдлага

Албан тушаал: , МУИС, Санхүүгийн тэнхимийн ахлах багш



Б.Ариунболд

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Мэргэжил: Санхүү, эдийн засаг

Албан тушаал: “Интергруп Интернэйшнл ХХК” Санхүү эрхэлсэн захирал

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 10

**“Үндэсний Хувьчлалын Сан”
Хамтын ХОС-ийн Хөрөнгө
Оруулалтын бодлогод өөрчлөлт
оруулах**

Үндэсний Хувьчлалын Сан Хамтын ХОС-ийн Хөрөнгө Оруулалтын бодлогод өөрчлөлт оруулах

Сан нь нийт зарласан нэгж эрхийн 5 хүртэлх хувь буюу 2,500,000 ширхэг хүртэлх нэгж эрхийг нэгж эрхийн зах зээлийн ханш тухайн үеийн цэвэр хөрөнгийн үнэлгээ (NAV)-ээс 15 ба түүнээс дээш хувиар бага үнэлэгдэж байгаа тохиолдолд зах зээлээс эргүүлэн авах ажиллагааг хэрэгжүүлж болно.

Сангийн нэгж эрхийг буцаан худалдан авах ажиллагаа нь нэгж эрхийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, нэгж эрх эзэмшигчдийн эрх, ашгийг хамгаалах зорилготой байх бөгөөд Сангийн ТУЗ-өөс баталсан журам болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжинэ.

Сан нь буцаан худалдан авсан нэгж эрхээ Сангийн үйл ажиллагааны хугацаа дуусахаас өмнө нэгж эрхийн цэвэр хөрөнгийн үнэлгээ (NAV), Сангийн ТУЗ-өөс баталсан журам, холбогдох шийдвэрийн дагуу зах зээлд буцаан арилжиж болно.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 11

**“Үндэсний Хувьчлалын Сан”
Хамтын ХОС-ийн нэгж эрхийн
танилцуулгад өөрчлөлт оруулах**


Нэгж эрхийн танилцуулгад өөрчлөлт оруулах

Сан нь нийт зарласан нэгж эрхийн 5 хүртэлх хувь буюу 2,500,000 ширхэг хүртэлх нэгж эрхийг нэгж эрхийн зах зээлийн ханш тухайн үеийн цэвэр хөрөнгийн үнэлгээ (NAV)-ээс 15 ба түүнээс дээш хувиар бага үнэлэгдэж байгаа тохиолдолд зах зээлээс эргүүлэн авах ажиллагааг хэрэгжүүлж болно.

Сангийн нэгж эрхийг буцаан худалдан авах ажиллагаа нь нэгж эрхийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, нэгж эрх эзэмшигчдийн эрх, ашгийг хамгаалах зорилготой байх бөгөөд Сангийн ТУЗ-өөс баталсан журам болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжинэ.

Сан нь буцаан худалдан авсан нэгж эрхээ Сангийн үйл ажиллагааны хугацаа дуусахаас өмнө нэгж эрхийн цэвэр хөрөнгийн үнэлгээ (NAV), Сангийн ТУЗ-өөс баталсан журам, холбогдох шийдвэрийн дагуу зах зээлд буцаан арилжиж болно.

Санал хураалт





**САНАЛ ХУРААЛТЫН ДҮН,
ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ №2



ҮНДЭСНИЙ
ХУВЬЧЛАЛЫН
САН

“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХАМТЫН ХОС-ИЙН НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ №2

2026 оны 4 сарын 28-ны өдөр

Санал хураалтын дүнгийн талаар

Компанийн нэр: “ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХАМТЫН ХОС

Хурлын төрөл: Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурал

Нэгж эрх эзэмшигчдийн хурал хуралдсан огноо, газар: 2026 оны 04 сарын 28-ны 15:00 цагт, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Сүхбаатарын талбай-2, Сентрал Тауэр, 17 давхар, Криптос ресторан

Бүртгэлийн өдөр: 2026 оны 04 сарын 08-ны өдөр

Нэгж эрх эзэмшигчдийн хурлын урьдчилсан саналын хуудас ирүүлсэн сүүлийн хугацаа: 2025 оны 04 сарын 27-ны өдрийн 16:00 цаг хүртэл

Тооллогын комисс: Ө.Бямбагэрэл

Санал хураалт:

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.14, 62.1.16 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2.3 дугаар зүйлийн дагуу хуралд оролцсон болон саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн саналыг тоолж санал хураалтын дүнг нэгтгэснийг ТОГТООХ НЬ:

ХУРЛААС ГАРСАН ШИЙДВЭР

“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХАМТЫН ХОС-ИЙН
НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайланд
хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай*

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь хэсэг, “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн 2026 оны Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ард Менежмент” ХХК-ийн хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу үзүүлсэн үйлчилгээний 2025 оны жилийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ДАВААСАМБУУ

“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХАМТЫН ХОС-ИЙН НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

үйл ажиллагааны тайланд “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн 2025 оны санхүүгийн болон хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх хэсэг, “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн 2026 оны Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ДАВААСАМБУУ

“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХАМТЫН ХОС-ИЙН НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Кастодиан банкны хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайланд хийсэн

ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь хэсэг, “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн 2026 оны Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Голомт банк” ХК-ийн Кастодиан банкны хэлтсийн хөрөнгө хадгалах үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу үзүүлсэн үйлчилгээний 2025 оны жилийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ДАВААСАМБУУ

“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХАМТЫН ХОС-ИЙН НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг батлах тухай

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх хэсэг, “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн 2026 оны Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ДАВААСАМБУУ

“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХАМТЫН ХОС-ИЙН НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Кастодиан банк өөрчлөх тухай

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 51 дүгээр зүйлийн 51.1.1 дэх хэсэг, Голомт банк ХК-тай 2020 оны 6 сарын 9-ний өдөр байгуулсан ГК-2020/12 дугаар Хөрөнгө хадгалах, Кастодианы үйлчилгээний гэрээний 12 дугаар зүйлийн 12.3.3 дахь хэсэг, “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС (цаашид “Сан” гэх)-ийн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.2.11, Сангийн 2026 оны Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сангийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан Кастодиан банк өөрчлөх тухай шийдвэрийг баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Санд үйлчилгээ үзүүлэгч “Ард Менежмент” ХХК-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ДАВААСАМБУУ

“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХАМТЫН ХОС-ИЙН НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Хөрөнгө оруулалтын бодлогод өөрчлөлт оруулах тухай

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.4, 26 дугаар зүйлийн 26.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам”-ын 16 дугаар зүйл, “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн 2026 оны Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан Нэгж эрх эргүүлэн худалдан авах журам болон Кастодиан банк өөрчлөх тухай шийдвэрт тус тус холбогдуулан “Хөрөнгө оруулалтын бодлого”-д өөрчлөлт оруулж, Хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Хөрөнгө оруулалтын бодлого, активын шаардлагад нийцүүлэн сангийн хөрөнгийг удирдаж ажиллахыг “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-д үйлчилгээ үзүүлэгч “Ард Менежмент” ХХК-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ДАВААСАМБУУ

“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХАМТЫН ХОС-ИЙН НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*“Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн
дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай*

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2, 16.1.3, 16.1.5, 16.1.7, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйл, “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн 2026 оны Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС (цаашид “Сан” гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан Нэгж эрх эргүүлэн худалдан авах журам болон Кастодиан банк өөрчлөх тухай шийдвэрт тус тус холбогдуулан Сангийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж, Хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ДАВААСАМБУУ

“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХАМТЫН ХОС-ИЙН НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Нэгж эрхийн танилцуулгад өөрчлөлт оруулах тухай

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.4, 26 дугаар зүйлийн 26.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам”-ын 16 дугаар зүйл, “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн 2026 оны Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан Нэгж эрх эргүүлэн худалдан авах журам болон Кастодиан банк өөрчлөх тухай шийдвэрт тус тус холбогдуулан “Нэгж эрхийн танилцуулга”-д өөрчлөлт оруулж, Хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Хөрөнгө оруулалтын бодлого, активын шаардлагад нийцүүлэн сангийн хөрөнгийг удирдаж ажиллахыг “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-д үйлчилгээ үзүүлэгч “Ард Менежмент” ХХК-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ДАВААСАМБУУ

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХАМТЫН ХОС-ИЙН
НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**



ҮНДЭСНИЙ
ХУВЬЧЛАЛЫН
САН

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд сонгох тухай

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС (цаашид “Сан” гэх)-ийн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.2.6 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг, Сангийн 2026 оны Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн
ТОГТООХ нь:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд дор дурдсан нэр бүхий гишүүнийг сонгон, томилсугай. Үүнд:

№	Ердийн гишүүдийн нэрс
1	Хүрэлбаатарын Билгүүн
2	Галбадрахын Цогбадрах
3	Чадраабалын Даваасамбуу

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдэд нэр дэвшигч:

№	Ердийн гишүүдийн нэрс
1	Батхүүгийн Ариунболд
2	Пүрэвийн Баянсан

3. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ДАВААСАМБУУ

“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХАМТЫН ХОС-ИЙН НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсөв батлах тухай

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь хэсэг, 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг болон “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн 2026 оны Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсвийг Хавсралтын дагуу баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга, нягтлан бодогч нарт тус тус даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ДАВААСАМБУУ

Хурлын хаалт